

**Эрдэнэ мэргэн бандида, Ханчин хамба Жамъянгаравын  
залбирал шүлгийн тухай**

**Банзарын ОЮУНБИЛЭГ\***

*Монгол Улс, Улаанбаатар,  
Намдолдэчинлин хийд*

**Received:** Jun 13, 2025 | **Revised:** Dec 21, 2025 | **Accepted:** Dec 18, 2025

***Хураангуй:** Хуучнаар Сайн ноён хан аймгийн Даянжалбуу засгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Жаргалант сумын нутгаас тодорч цолгорсон Бат сүжигт, бандида хамба Сүрэнхорын Жамъянгаравын намтар бүтээлийн талаарх судалгаа шинжилгээний ажил манай үе үеийн эрдэмтэн судлаачдын ач буянаар багагүй амжилтыг олоод байгаа билээ. Гэгээнтний үлдээсэн их өв сан зохиол бүтээл нь цагийн будангуйд бидний гарт бүрэн бүтнээрээ уламжлаагүй боловч түүний үр ач, ах дүүс, нутгийн зон олноос нэлээд олдож судалгаа шинжилгээний эргэлтэд орсоор байгааг энд тэмдэглэх нь зүйтэй юм. Энэхүү өгүүлэлд бид Эрдэнэ мэргэн бандида ханчин хамба Жамъянгаравын зургаа дахь охин Додгучарвийн охин Чанцалдуламын шүтээнд хадгалагдаж буй нэгэн бичмэл судрын тухай өгүүлэх юм.*

***Түлхүүр үг:** Ханчин хамба Жамъянгарав, зохиол бүтээл, залбирал шүлэг.*

**About One Prayer Poem Composed by Gem Wise Pandit,  
Khenchen Rinpoche Jamiyengarav**

OYUNBILEG Banzar

*Namdoldechenlin monastery  
Ulaanbaatar, Mongolia*

***Abstract:** The study works on a biography and creative scholarship of Surenkhoryn Jamiyengarav, a Durable Faith Pandit Rinpoche who was born and recognized as a tulku in the Dayanjaltbuu Governor's Banner, Sain Noyon (Good King) Khan Aimag according to the old terminology or in the current Jargalant Soum territory, Arkhangai Aimag have been achieving a notable success thanks to efforts of our various generation scholars and researchers. It is worth mentioning that despite the great legacies left by the Rinpoche didn't reach us in full due to turbulent and vulnerable times, his scholarship works continue to be*

---

\* © Б.Оюунбилэг 2025  
Email: gang8mn@gmail.com

*found among his descendants, relatives and local community people and circulated into the scientific research circles. We will narrate on one manuscript sutra kept in the shrine of Chantsaldulam, a daughter of the sixth daughter Dodgucharvi of Gem Wise Pandit Khenchen Rinpoche Jamiyengarav.*

**Key words:** *Khenchen Rinpoche Jamiyengarav, creative scholarship, prayer poem.*

## 1. Удиртгал

XIX зууны их бичгийн хүн, утга зохиолын онолч, буддын гүн ухаантан, бурхан шашны нэрт зүтгэлтэн Сүрэнхорын Жамъянгарав нь монголын төвөд хэлт уран зохиолын гол төлөөлөгчдийн нэг мөн. Түүний зохиол бүтээлийн талаар Гандан хийдийн хамба асан С.Гомбожав 1959 онд Олон улсын монгол эрдэмтдийн анхдугаар их хуралд хэлэлцүүлсэн “Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл” илтгэлдээ төвөд хэлээр зохиол бүтээлээ туурвидаг хоёр зуу гаруй монгол эрдэмтэн лам хуврагийг дурдсан бөгөөд тэдгээрийн дунд “73. Жамъянгарав. Сайн ноён хан аймгийн Даян жалбуу засгийн хошууны хамба, гэгээн. XX зууны үеийн хүн, зохиол нь арван гурван боть, уран зохиолын онол зэрэг, мөн хошуундаа бартай” (Гомбожав, 1959: 32) гэж тэмдэглэсэн байна.

Энэ үеэс гэгээнтний намтар, монголын утга соёлын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, зохиол бүтээлийн судалгааг нарийвчлан судалж тодруулах ажил нь академич Ц.Дамдинсүрэн, Ч.Алтангэрэл (1977: 623-627), Д.Цэрэнсодном (1975: 240-244), Л.Хүрэлбаатар нарын зэрэг манай ахмад эрдэмтдийн хичээл зүтгэлийн үрээр нэлээд цэгцэрсэн гэж болно. Эдгээр эрдэмтдний дотроос төвөдч эрдэмтэн Л.Хүрэлбаатарын судалгаа шинжилгээний ажлыг дэлгэрүүлэн өгүүлэх хэрэгтэй. Тэрээр “Найлзуур модны мөчрийн дэргэд” /XIX-XX зууны эхэн үеийн монголын яруу найргийн онолч, яруу найрагч Сүрэнхорын Жамъянгарав/ (1991), “Дандины “Зохист аялгууны толийн” тайлбарт Жамъянгаравын хийсэн бүтээлч шинэчлэл” (1992) зэрэг өгүүллийг бичиж хэвлүүлсний зэрэгцээ “Эсэруагийн эгшиг дуун” (Эрдэнэ мэргэн бандида, Ханчин хамбо Жамъянгаравын яруу үгийн онолд хийсэн шинжлэл) (1999) хэмээх нэг сэдэвт бүтээлийг нийтлүүлсэн нь Жамъянгаравын сор болсон бүтээлийг гадаад дотоодын эрдэмтэн судлаач, оюутан залуучууд, уран зохиол яруу найргийг сонирхогчдод шинжлэн судалж, сурталчлан таниулсан чухал гарын авлага болохуйц үнэ цэнтэй ажил юм.

Мөн сүүл үес судлаач, доктор (Ph.D) Д.Ганболд гэгээнтний намтар, зохиол бүтээлтэй холбогдуулан олон ажлыг хийж хэвлүүлээд байна. Тухайлбал Д.Ганболд “Бат сүзэгт, бандида хамбо Жамъянгаравын сүмбумын гарчиг” (2011), “Бат сүзэгт, бандида хамба Жамъянгаравын намтрыг дэлгэрүүлэх хэдэн мэдээ” (2013), “Бат сүзэгт, бандида хамба Жамъянгаравын тааллын шим “дан-эй намжэд” хэмээх судрын тухайд” (2015) “Бат сүзэгт, бандида хамбын сүмбумд дурдагдсан бүтээлийг ахин тодлох нь” (2023) зэрэг олон өгүүллийг бичсэн байна. Түүнчлэн “Жамъянгарав судлал - I” (Намтар сэлтийн орчуулга ба судлалын бүтээлийн эмхтгэл) бүтээлийг 2013 онд “Жамъянгарав судлал - II” (Сүнбумын Ха, Га боть) – ыг 2015 онд, “Жамъянгарав судлал - III” (Сүүлийн 10 жилд судалсан бүтээлүүд) –ыг 2021 онд тус тус хэвлүүлээд байгаа билээ.

Мөн үүнийг бичигч миний бие дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд “Эрдэнэ мэргэн бандид, ханчин хамбо Сүрэнхорын Жамъянгарав (1861-1918)” (2021), “С.Жамъянгарав нь буддын гүн ухааны сэтгэлгээний томоохон төлөөлөгч болох нь” (2022), гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд “Жамъянгарав, известный буддийский деятель, поэтический теоретик и писатель конца 19-го и начала 20-го веков” (2022) зэрэг эрдэм шинжилгээний өгүүллийг тус тус хэвлүүлээд байна.

Эдгээр эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнд Жамъянгарав гэгээнтний намтар хийгээд бүрэн зохиолын гарчигт дурдагдсан хэд хэдэн боть сүнбүм зохиолоос одоогийн байдлаар хорь гаруйг нь олж илрүүлээд байгаа юм.

Монголын эрдэмтэн лам хуврагуудын төвөд хэлээр туурвисан зохиол бүтээл нь нийт монгол даяар бичмэл дармалаар түгээмэл тархсан байдаг ч Эрдэнэ мэргэнэ бандида, ханчин хамба Жамъянгаравт холбогдох ном судар төдийлөн элбэг биш байна. Манай улсын Үндэсний номын сангийн төвөд номын сан хөмрөгт хэдэн арван мянган баринтаг ном судар бий боловч бүгдийг хараахан бүртгэлжүүлж амжаагүй, олонх нь баринтаг шоголын цаана огтоос судлагдаагүй эрхэм нандин хэвээрээ оршсоор байгаа бөгөөд үүнд хүн хүч, хөрөнгө санхүүгийн асуудал гэх мэт бидний мэдэхгүй зүйлс байдаг биз ээ.

## 2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Бид энэхүү судалгаанд Эрдэнэ мэргэн бандида, ханчин хамба Жамъянгаравын зургаа дахь охин Додгүчарвийн охин Чанцалдуламын шүтээнд хадгалагдаж буй гарчиггүй нэгэн бяцхан гар бичмэл судрыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон, эх хэрэглэгдэхүүнээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх түгээмэл аргыг ашигласан болно.

## 3. Судалгааны хэсэг

“dbyangs can lha mo mgrin par chags pa yis” хэмээж эхэлсэн энэхүү судрын хэмжээ нь 20x9 (17x7) см, дөрвөн булан нь нэлээд сэмэрч муудсан байдалтай бөгөөд хятад муутуу цааснаа нэг нүүрт 6 мөрөөр бийрээр бичсэн хоёр хуудас бичмэл. Уг судрыг бүхэлд нь эрдэм шинжилгээний галигаар буулган үзүүлбэл:

[1a] *dbyangs can lha mo mgrin par chags pa yis //*

*'jam dbyangs rnam 'phrul rje btsun btsong kha pa 'i //*

*mdo sngags bstan pa 'i ba dan dkar po nyid //*

*phyogs bcur ga-yo mdzad drin can bla mar 'dud //*

*aom a 'a: gu ru badzra dha ra manydzu shr 'i sit 'a siddhi h 'um/*

*dpal ldan bla ma 'i rnam par thar pa la //*

*skad cig tsam yang log lta ma skye zhing //*

*ci mdzad legs par mthong ba 'i mos gus skied //*

*bla ma 'i byin rlabs sems la 'jug par shog /*

[1e] *ngag gi dbang phyugs rgyal kun bskyed pa 'i yab //*

*ngur smrig gar rol blo bzang rgyal ba yis //*

bshad sgrub chos 'byor don kun 'grub byed pa'i //  
 bka' drin gsum ldan bla mar gsol ba 'debs //  
 aom a'a gu ru badzra dha r'a wa ghintra dharm'a bhu ti aartha siddhi h'um h'um /  
 skye ba kun tu yang dag bla ma dang //  
 [x] myur thob shog /  
**[2a]** dbyangs can lha mo mgrin par chags pa yis //  
 'jam dbyangs rnam 'phrul rje btsun btsong kha pa'i //  
 mdo sngags bstan pa'i ba dan dkar po nyid //  
 phyogs bcur ga-yo mdzad drin can bla mar 'dud //  
 aom a'a: gu ru badzra dha ra manydzu shr'i sit'a siddhi h'um/  
 dpal ldan bla ma'i rnam par thar pa la //  
 skad cig tsam yang log lta ma skye zhing //  
 ci mdzad legs par mthong ba'i mos gus skied //  
 bla ma'i byin rlabs sems la 'jug par shog /  
 na mo gu ru bhya:  
 'jam mgon bla ma'i bstan pa'i gru gzings la //  
 legs par bsten nas thar pa'i lu **dbyangs** blangs //  
 lhag bsam rnam par **dkar po'i** dar 'phyar ba //  
 drin can dge ba'i shegs la gsol ba 'debs //  
**[2e]** aom a'a: gu ru manydzu gho sha si t'a siddhi h'um h'um //  
 deng nas brtsams ste tshe rabs kun du bdag /  
 khyod zhabs padmo gus pas mchod nas ni //  
 ci gsung bka' bzhin sgrubs pas mnyes byas nas //  
 sa lam bgrod pa myur du mthar phyin shog /  
 khyad par ma 'ongs byang phyogs shambha lar //  
 rigs ldan 'khor bsgyur sras kyi thu bo'i drung //  
 blon por gyur tshe bdag kyang rjes bzung nas //  
 stong gzugs phyag rgya chen po 'grub par shog  
 dga' ldan dge 'phel gling gi chos grva ru /  
 'chad nyan slob gnyer 'dzin cing khyad par du /

*padma yang gsang zab gter tshar rab phye /*

*grub dbang dma zer mtshan can bla ma 'dud / dge legs gyur cig /*

Энд тодруулж өгсөн “**jam dbyangs dkar po**” гэсэн үгийг улаан шунхаар онгин тэмдэг тавьсныг зааж буй юм. Харин уул “**jam dbyangs dkar po**” гэдэг үгийг доогуур нь зурж тэмдэглэсэн нь судар дээр өмнөхийн адил онгин тэмдэглэгээ хийгээгүй боловч өөрийн нэрээ оролцуулан шүлэглэсэн хэсэг гэдгийг илтгэхийн тулд ийнхүү ялгасан гэдгийг дурдъя.

Энэхүү судар нь төвөдийн ес есөн үеэр тэнцүүлэн шүлэглэн бичсэн нийтдээ 36 мөр байна. Үүнд нэг анхаарууштай гэх үү сонирхол татах зүйл буй нь уг судрын эхний найман мөр буюу хоёр бадаг нь дараагийн хоёрдугаар нүүрт ахин давтагдаж буй явдал юм. Гэвч чухам ямар учиртай болох, нарийн холбоо хамаарлыг одоо бид нэхэн хэлэлцэхэд бэрхшээлтэй. Магадгүй үүнийг хуулан бичээч юм уу өөр хэн нэгэн хүн зориудаар давхардуулан бичсэн байхыг үгүйсгэх аргагүй гэдгийг тэмдэглэх нь зохистой.

Судрын үгчилсэн орчуулгыг сонирхуулбал:

*“Янжин лхамын хоолойд тогтсон*

*[Ялгуусан] Зөөлөн эгшигтийн (Жамъян) тийн хувилгаан богд Зонховын*

*[Ялгуугч] судар тарнийн шашны гагц цагаан (гарав) бааданг*

*[Ямагт] арван зүгт хөдөлгөн зохиогч ачит багш дор сөгдмүү.*

**Ум а гүрү базар дара манзуири сида сидди хум хум.**

*Цог төгөлдөр багшийн тийн гэтэлсэн намтарт*

*Эгшин төдий ч буруу үзэл үл төрүүлэх бөгөөд*

*Юу зохиосон ч сайнаар харах дуриил бишрэлийг үүсгэснээр*

*Багшийн адистид сэтгэлд орох болтугай.*

**Багш дор мөргөмүү.**

*Зөөлөн (Жам) итгэлт багшийн шашны усан онгоцонд*

*Сайтар шүтээд гэтлэхүйн дуун эгшигийг (ян) дуулаад*

*Үлэмж сэтгэлийн тийн цагаан (гарав) тугийг хийсгээж*

*Ачит буяны саданд залбирмуу*

**Ум а гүрү манзугоша сида сидди хум хум.**

*Эдүгээгээс эхлээд төрөл тутамдаа би*

*Таны өлмийн лянхуаг бишрэлээр тахиад*

*Юу зарлигласныг зарлигчлан бүтээн баясгаад*

*Гэгээрлийн газар мөрд зорчиж үтэр туйлд хүргэх болтугай.*

*Ялангуяа ирээдүйд умар зүгийн шамбалын оронд*

*Язгуур төгс хүрдэн урвуулагч хааны ууган хөвгүүний дэргэд*

*Ноён болох цагт би ч даган бариад*

*Хоосон дүрст Маха мудрааг бүтээх болтугай.*

*Сайн буян болтугай”*

Уг судрын бүтцийг тодруулан өгүүлбэл залбирлын хэсэг, тарнийн хэсэг, ерөөлийн хэсэг гэсэн гурван үндсэн хэсэгт хувааж болно.

**Залбирлын хэсэг.** Эхний дөрвөн мөр буюу нэг бадаг шүлэг Янжинлхам бурхныг магтсан хэсэг багтаж байна. Янжинлхам бурхан нь эрдэм мэдлэг, билиг оюуныг бэлгэ тэмдэг бөгөөд монголоор Эгшигт охин тэнгэр гэсэн утгатай. Аливаа бурхдад тэргүүн, хоолой, зүрх, хүйс, нууцын орон гэх таван судлын хүрд байдаг. Тэдгээр таван хүрдний дотроос хоолойн хүрдэнд тогтсон гэдгээр Жамьянгараг хувилгааныг Янжинлхам бурхны зарлигийг эрхшээж шашин амьтны тусыг бүтээхдээ дээдийн номыг номлох, олон номд тайлбар сэлт үйлдэхийг онцгойлон харуулж байна.



Богд Зонховыг Манзушир бурхны хувилгаан дүр гэдэг. Түүнийг Манзушир бурхны хувилгаан дүр болохыг олон шастир, судар, дандарт эш бошго үзүүлсэн бошго үзүүлсэн байдаг. Санскрит хэлний Манзушир гэх үгийг төвөдөөр Жамьян, монголоор Зөөлөн эгшигт гэж хөрвүүлдэг. Ялгуусан бурхан багшийн айлдсан билгийн чанад хязгаараа хүрэхүйн хөлгөн болох судрын ном, очирт хөлгөн тарнийн номын шашны цагаан туг бааданг (Бурхны шашныг цагаан туг баадантай үлгэрлэж хэлжээ. (Б.О)) зүг бүхэнд сайтар дэлгэрүүлсэн хэмжээлшгүй ачит багш Жамьянгараг хувилгаанд мөргөмүү хэмээх утгыг залбиралд илэрхийлжээ.

**Тарнийн хэсэг.** “Ум а гүрү базар дара манзушри сида сидди хум” хэмээх тарни бий бөгөөд Жамьянгараг хувилгааны өөрийн нэрийн тарни, зүрхэн тарни нь байна. **Ум** гэдэг тарни нь эгэл хүмүүний биеийг эгэлгүй бурхны лагшин болгодог тарни. **А** гэдэг тарни нь эгэл хүмүүний хэлийг эгэлгүй бурхны зарлиг болгодог тарни. **Гүрү** нь багш, дээдэс гэсэн утгатай. **Базар дара** нь очир баригч, очрыг эрхшээгч гэсэн утгатай. **Манзушри сида** нь төвөдөөр Жамбалгараг (Жамьянгарагтай нэг утгатай), монголоор Цагаан зөөлөн цогт бурхан гэсэн утгатай. **Сидди** гэдэг нь ид шид гэсэн утгатай. **Хум** гэдэг нь эгэл хүмүүний сэтгэлийг эгэлгүй бурхны таалал болгодог тарни. **Хум** тарнийг хоёр дахин оруулсан “Очирдара бурхны мөн чанарт Жамьянгараг хувилгаан багш та хоёр дахин илүү хурдан шид бүтээлийг надад хайрлагтун” хэмээх утгыг илэрхийлжээ. Энэхүү тарни нь Очирдара Жамьянгараг багш минь ээ! Эгэл миний бие, хэл, сэтгэл гурвыг эгэлгүй төгс бурхны лагшин зарлиг таалал болгох шид бүтээлийг хайрла хэмээсэн утга бүхий тарни юм.

**Ерөөлийн хэсэг нь** дээрх тарни тогтоолын дараагаар эхлэх бөгөөд Умард зүгийн Шамбалын оронд ирээдүйд халхын Жавзандамба хутагт тэргүүтэн төрөөд амьтны тусыг бүтээх цагт Жамьянгараг хувилгаан нэгэн ноён болж даган төрөөд шашин амьтны тусыг хамт бүтээнэ хэмээжээ. Тэр цагт бид ч хамт төрөөд маха мутра Дүйнхор бурхны хутгийг олоод амьтны тусыг бүтээх болтугай гэсэн ерөөлийг дэвшүүлсэн байна.

Эл сударт Жамъянгарав шүлэглэн, үе тэнцүүлэн бичдэг эртний Энэтхэг, Төвөдийн бичгийн хэлнээ уламжлан Монголын утга зохиолын хэлэнд тогтсон сонгодог бичгийн найруулга, уран зохиолын дүр дүрслэлийг бүтээх сэтгэлгээний арга, дэг жаягийг нарийн чанд баримтлахын зэрэгцээ үг сонголт, адилтгал зүйрлэлийг оновчтой хэрэглэн өөрийн нэрийг оруулан Бурхандаа өөрийн өмнөөс яруу сайхныг илэрхийлэн залбиран зохиосон байна.

Зураг №1. Б.Чанцалдуламын хувийн цуглуулгад буй эх



#### 4. Дүгнэлт

XIX зууны төвөд хэлт уран зохиолын гол төлөөлөгч Ханчин хамба Жамъянгаравын зохиол бүтээлийн олон зүйлийн дотор магтаал, сургаал, залбирал, элдэв зан үйлийн яруу найраг, зохист аялгууны толийн онол, түүний чимгүүдийн жишээ шүлэг зэрэг олон зүйл байх бөгөөд тэдгээрээс гарчигт багтаж тэмдэглэгдсэн хийгээд багтаагүй зохиол ч энэ хэр олдсоор байгаагийн жишээ нь бидний энд хэлэлцэн буй залбирлын шүлэг болно.

Энэ мэтээр Гэгээнтний судалгаа шинжилгээний олон нийтэд хүрээгүй, хэвлэн нийтлээгүй, түгэн дэлгэрээгүй зохиол бүтээл олон бий гэдэг нь эрдэмтдийн тэмдэглэж өнгөрсөн ботийн тоо, гарчиг бүртгэл зэрэг зүйлсээс хэдийнээ мэдэгдэж буй бөгөөд цаашид ч шинээр зохиол бүтээлүүд нь илэрсээр байх болно гэдэгт найдна.

Үүнийг бичигч миний бие Жамъянгарав гэгээнтний юум /эхнэр / Бунтар гэлэнгийн охин Замбалгарав хоёрын охид болох Сүгжилхам, Чойжилхам, Дүнжмаа, Цэрэннадмид, Сэлнинбанмо, Додгүчарви, Нямбуу хэмээх нутаг усандаа “Гэгээний долоон хонгор” нэрлэгддэг байсан охидуудын зургадугаар охин Додгүчарви, Додгүчарвийн дөрөвдэхь охин Доржхандын хоёрдахь охин билээ. Замбалгарав эмэг маань гэрийн сургуулиар төвөд, монгол ном орчуулгатай, бас жодын хурал хурдаг, ааш зан, ажил үйл, эрдэм ном төгс нэгэн байжээ. Миний эмээ ээж Додгүчарви мөн адил гэрийн боловсролтой эгч дүү долуулаа хурлаа хурдаг тухайн үеийн боловсролтой эмэгтэйн нэгэн байлаа. Эмээ маань 11 хүүхэд төрүүлсэнээс хамгийн бага Чанцалдулам

юм. Энэ залбирал судар нь Жамъянгаравын зээ Б.Чанцалпуламын гэрийн шүтээнд залагдаж байгаа билээ.

Үе үеийн эрдэмтэн судлаачид Ханчин хамба Жамъянгаравын зохиол бүтээлийг судлан шинжилж, сурталчлан түгээж, судалгааны хүрээнд оруулах, эрдэмтэд судлаачид, дэмжигчдийг нэгтгэх, тэдгээр ажлыг үргэжлүүлэн хийх дараа дараагийн суурийг тавьснаараа ач холбогдолтой билээ. “Үйлс өөсөөн бүтэх” хэмээн Эрдэнэ мэргэн ханчин хамбын өөрийнх нь айлдсанаар номын цагаан буян тасралтгүй өрнөн дэлгэрэх болтугай.

Принлэй-лхүндүв-вар жүржиг.

Үйл өөсөөн бүтэх болтугай.

### Ном зүй:

- Алтангэрэл, Ч.** (1977). *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн зохиолын онол*. Монголын уран зохиолын тойм. II боть. Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Уб., [Ch.Altangerel, Mongol zokhiolchdyn tövödөөр bichsen zokhiolyn onol. Vol II. [The Theory of Tibetan-Language Literature by Mongolian Writers, A Survey of Mongolian Literature, Ulaanbaatar, 1977]
- Бат сүзэгт бандида хамба Жамъянгарав*. Судлалын боть - I (2013). Эрхлэн хэвлүүлсэн Д.Ганболд. Уб., [Bat süjigt bandida khamba Jamiyengarav. Sudlalyn boti-I, Ulaanbaatar, 2013]
- Бат сүзэгт бандида хамба Жамъянгарав*. Судлалын боть - II (2015). Эрхлэн хэвлүүлсэн Д.Ганболд. Уб., [Bat süjigt bandida khamba Jamiyengarav. Sudlalyn boti-II, Ulaanbaatar, 2015]
- Бат сүзэгт бандида хамба Жамъянгарав*. Судлалын боть - III (2021). Эрхлэн хэвлүүлсэн Д.Ганболд, Ч.Пүрэвдорж. Уб., [Bat süjigt bandida khamba Jamiyengarav. Sudlalyn boti-III, Ulaanbaatar, 2021]
- Ганболд, Д.** (2011). *Бат сүзэгт, бандида хамбо Жамъянгаравын сүмбүмын гарчиг*. МУБИС, МоСС-ийн ЭШБ. № 47. Уб., [D.Ganbold, Bat süjigt bandida khamba Jamiyengaravyn sümbümiin garchig. Ulaanbaatar, 2011]
- Ганболд, Д.** (2013). *Бат сүзэгт, бандида хамба Жамъянгаравын намтрыг дэлгэрүүлэх хэдэн мэдээ*. Төвөд судлал. Боть 2. F.9. 144-151- тал. [D.Ganbold, Bat süjigt bandida khamba Jamiyengaravyn namtryg delgerüülekh kheden medee, Tibetan studeis, Vol 2, f. 9. Pp. 141-151]
- Ганболд, Д.** (2023). *Бат сүзэгт, бандида хамбын сүмбүмд дурдагдсан бүтээлийг ахин тодлох нь*. Уб., [D.Ganbold, Bat süjigt bandida khambyn sümbүмд durdagdsan бүтээлийг ахин todlokh ni, Ulaabaatar, 2023]
- Ганболд, Д.** (2015). *Бат сүзэгт, бандида хамба Жамъянгаравын тааллын шим “дан-эй намжэд” хэмээх судрын тухайд*. Төвөд судлал. Боть 4. F.11. 211-223-р тал. [D.Ganbold, Bat süjigt, bandida Khamba Jamiyengaravyn taallyn shim “drang nges rnam ’byed” khemeekh sudryn tukhaid, Tibetan studies, Vol 4. F. 11. Pp. 211-223]
- Гомбожав, С.** (1959). *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн зохиолын зүйл*. Studia Mongolica. Уб., [S.Gombojav, Mongol zokhiolchdyn tövödөөр bichsen zokhiolyn zүйл. Ulaanbaatar, 1959]
- Оюунбилэг, Б.** (2021). *Эрдэнэ мэргэн бандид, ханчин хамбо Сүрэнхорын Жамъянгарав (1861-1918)*. Хэл бичиг, утга соёл. Улаанбаатарын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. №17 (16) Уб., 124-128-р тал . [B.Oyunbileg, Erdene mergen bandida, khanchin khambo Sürenkhoryn Jamiyengarav (1861-1918). Khel

bichig, utga soyol, Ulaanbaatar ikh surguuliin erdem shinjilgeenii setgүүл №17 (16) Ulaanbaatar, pp. 148-128]

- Оюунбилэг, Б.** (2022). *С.Жамъянгарав нь буддын гүн ухааны сэтгэлгээний томоохон төлөөлөгч болох нь*. Монгол судлалын чуулган. МУБИС-ийн Эрдэм шинжилгээний сэтгүүл. №33. Уб., 159-170-р тал [B.Oyunbileg, S.Jamiyengarav ni buddyn gүн ukhaany setgelgeenii tomookhon төлөөлөгч bolokh ni, Mongol sudlalyn chuulgan. №33. Ulaanbaatar, pp. 159-170]
- Оюунбилэг, Б.** (2022). *Жамъянгарав, известный буддийский деятель, поэтический теоретик и писатель конца 19-го и начала 20-го веков*. Евразийский Союз Ученых. Серия: Филология, искусствоведение и культурология. Вып. 1. Санкт-Петербург. №03/96.
- Хүрэлбаатар, Л.** (1991). *“Найлзуур модны мөчрийн дэргэд” /XIX-XX зууны эхэн үеийн монголын яруу найргийн онолч, яруу найрагч Сүрэнхорын Жамъянгарав/*. – Цог сэтгүүл. №5. Уб., 78-107-р тал. [L.Khürelbaatar, Nailzuur modny möchriin derged, /XIX зууны ekhen үйиin mongolyn yарuu найргийн онолч, yарuu найрагч Sürenkhoryn Jamiyengarav/ Tsog. №5. Ulaanbaatar, pp. 78-107]
- Хүрэлбаатар, Л.** (1992). *Дандины “Зохист аялгууны толийн” тайлбарт Жамъянгаравын хийсэн бүтээлч шинэчлэл*. – Олон улсын монголч эрдэмтний V их хурал, III боть, Уб., 29-35-р тал. [L.Khürelbaatar, Dandiny “Zokist ayanlguuny toliin” tailbart Jamiyengaravyn khiisen бүтээлч shinechlel, Olon ulsyn mongolch erdemtnii V ikh khural, III boti, Ulaanbaatar, 29-35, 1992]
- Цэрэнсодном, Д.** (1975). *Яруу найргийн онолч Жамъянгарав*. Хэл зохиол судлал. Том.XI. f.19. 240-244-р тал. [D.Tserensodnom, Yарuu найргийн онолч Jamiyengarav. Khel zokhiol sudlal. Tom.XI. f.19. pp. 240-244]



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>